



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Д.ДЭЛГЭРЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 03/22 ЧАТ-САТ/2014/25/СТИА-ТНУЗ

Зардлыг төлүүлэх тухай

Эрчим хүчний яамны аппаратын 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрчим хүчний яамны аппаратын төсвийн санхүүжилтээр үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтнууд зардлын нормативын хэмжээг Сайд М.Сономпил 3593.5 мянга, Дэд сайд Д.Доржпүрэв 626.3 мянга, Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт 283.7 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын “Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт, зардлын норматив батлах тухай” 84 дүгээр тогтоолын 2-т “Энэ тогтоолын хавсралтад заасан албан тушаалтны үүрэн телефон хэрэглэх зардлын нормативыг Засгийн газрын гишүүн...улс хоорондын ярианы эрхтэйгээр, нэг сард 150.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байхаар/Засгийн газрын 2001 оны 58 дугаар тогтоолын өөрчлөлтийг тусгав/, бусад албан тушаалтанд улс хоорондын ярианы эрхгүй нэг сард 65.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байхаар тогтоосугай” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Эрчим хүчний яамны аппаратын төсвийн санхүүжилтээр үүрэн телефоны зардлын нормативыг нийт 4503,5 мян төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсныг холбогдох албан тушаалтнаар төлүүлж Улсын төсвийн орлогын төрийн сан дахь 900000601 дүгээр дансанд төвлөрүүлэн биелэлтийг 2014 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт Нягтлан бодогч П.Энхцэлмэг нарт хариуцуулав.

АКТ

